



Биологийн олон янз байдлын "Айчи-20 зорилтууд"

Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Талуудын бага хурлын 10 дугаар хуралдаанаас "Айчи – 20 зорилт"-ыг шинээр боловсруулан баталж, конвенцид нэгдэн орсон орон бүрийг өөрийн улс орны биологийн олон янз байдлын хөтөлбөрийг тус зорилтод нийцүүлэн шинэчлэн боловсруулах зөвлөмжийг гаргасан.

IMAGES FROM THINKSTOCKPHOTOS.COM



Secretariat of the Convention on Biological Diversity

World Trade Centre, 413 St. Jacques Street, Suite 800
Montreal, Quebec, Canada H2Y 1N9
Phone: 1(514) 288 2220 Fax: 1 (514) 288 6588
E-mail: secretariat@cbd.int Website: www.cbd.int



Биологийн олон янз байдал гэдэг нь дэлхий дээрх амьд биед организмын олон янз байдал тухайлбал хуурай газар, далай тэнгис, усан орчны экосистем, экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох амьтан, ургамал зэрэг амьд биет болон тэдгээрийн генетикийн олон янз байдлыг багтаасан нийлмэл ойлголт юм.

"Айчи"- гийн зорилтууд

Стратегийн зорилго А: Засгийн газрын болон нийгмийн зонхилох чиг хандлагыг биологийн олон янз байдлын хомсдлын шалтгаанд хандуулах



2020 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр хүмүүс биологийн олон янз байдлын үнэ цэнэ, ач холбогдлыг ойлгож, түүнийг хамгаалах, зохистой ашиглах алхамуудыг хийж эхлэх



2020 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр биологийн төрөл зүйлийн үнэ цэнийн тухай асуудлыг үндэсний болон орон нутгийн хөгжил, ядуурлыг бууруулах стратегийн бодлого, төлөвлөлт, үндэсний төсөв, тайлангийн системд тусгасан байх



2020 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг багасгах үүднээс хор хохирол учруулахуйц үйл ажиллагааг дэмжихгүй байх, харин түүнийг хамгаалах, зүй зохистой ашиглахыг дэмжсэн конвенцийн болон олон улсын хууль тогтоомжтой нийцэхүйц арга хэмжээг үндэсний нийгэм эдийн засгийн бодлогодоо тусгах



2020 он гэхэд буюу түүнээс хойшлуулахгүйгээр Засгийн газар болон бизнес, санхүүгийн бүх талууд зохистой үйлдвэрлэл, хэрэглээг дэмжсэн төлөвлөлтийг хэрэгжүүлж эхлэх, экологийн даац, тодорхой хязгаарын хэмжээнд байгаль орчны нөөцийг ашигладаг болсон байх

Стратегийн зорилго Б: Биологийн олон янз байдалд үзүүлэх шууд дарамтыг бууруулах, тогтвортой хэрэглээг хөхиүлэн дэмжих



2020 он гэхэд байгалийн нөөцийн ялангуяа ойн нөөцийн хомсдлыг хамгийн багадаа тал хувиар бууруулах боломжит нөхцөлд тэглэх болон түүний элэгдэл доройтлыг их хэмжээгээр багасгах



2020 он гэхэд загас, сээр нуруутан болон усны ургамлын зөв зохицуулалттай ашиглалтыг бий болгохын тулд экосистемд суурилсан аргагүй, хууль эрх зүйн аргуудыг ашиглан хууль бус загас агнуурыг багасгах, цөөрч буй төрөл зүйлүүдэд хяналт тавих, загас агнуурыг төрөл зүйлийн тоо болон экосистемийн төлөв байдал, зах зээлд нөлөөлөхгүйгээр экологийн тодорхой даац, хязгаарын дотор авч үзэх



2020 он гэхэд ХАА, ой болон усан сан бүхий газрын тогтвортой менежмент бий болсноор биологийн олон янз байдал хамгаалагдсан байх



2020 он бүх төрлийн бохирдол түүний дотор шим тэжээлийн илүүдлээс гаралтай бохирдлыг экосистемийн үйлчилгээ, биологийн олон янз байдалд хор хөнөөлгүй байх түвшинд хүргэх



2020 он гэхэд түрэмгий харь зүйл, түүний дамжиж тархах замыг тодорхойлох, хор хөнөөлөөр нь ангилах, нэн тэргүүнд анхаарах зүйлийг хяналтанд авах эсвэл устгах, тэдгээрийн тухайн газар нутагт суурьшихаас сэргийлэх арга хэмжээг авах



2015 он гэхэд уур амьсгалын өөрчлөлт болон далайн хүчиллэгжих үйл явцын нөлөөгөөр шүрэн хад болон бусад эмзэг экосистемүүдэд үзүүлж буй гадны нөлөөллийг бууруулж, экосистемийн бүрэн бүтэн байдал, үйлчилгээг хэвээр хадгалах

Стратегийн зорилго В: Экосистем, зүйл, генетикийн олон янз байдлыг хамгаалснаар биологийн олон янз байдлын төлөвийг сайжруулах;



2020 он гэхэд экосистемийн үйлчилгээ, биологийн олон янз байдлын хувьд онцгой ач холбогдол бүхий эх газрын 17 хувь, далайн тэнгис түүний эрэг орчмын газрын 10 хувийг хамгаалалтанд авч, түүний менежментийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх



2020 он гэхэд устах аюулд орсон төрөл зүйлүүд хамгаалагдаж, ялангуяа тоо толгой нь эрс хорогдож буй зүйлүүдийн байдал сайжирч тогтворжсон байх



2020 он гэхэд таримал ургамал, гэрийн тэжээвэр амьтад, тэдгээрийн зэрлэг овог болон нийгэм-эдийн засаг, соёлын ач холбогдол бүхий зүйлийн генийн олон янз байдлыг хадгалан генийн доройтлыг багасгах стратегийг боловсруулж хэрэгжүүлэх

Стратегийн зорилго Г: Биологийн олон янз байдал болон бүх төрлийн экосистемийн үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх



2020 он гэхэд хүний ялангуяа эмэгтэйчүүд, уугуул иргэд, нутгийн оршин суугчид, ядуу болон эмзэг бүлгийн усан хангамж, эрүүл мэнд, амьжиргаа, сайн сайханд чухал үйлчилгээ үзүүлдэг экосистемүүдийг хамгаалах, нөхөн сэргээх



2020 он гэхэд доройтолд орсон экосистемийн 15-аас доошгүй хувийг нөхөн сэргээх замаар экосистемийн тэсвэрлэх чадавхи, биологийн олон

янз байдлын нүүрсхүчлийн хийг шингээх чадварыг тэтгэх, улмаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, цөлжилттэй тэмцэхэд хувь нэмэр оруулах



2015-он гэхэд генийн нөөцийн ашиглалтаас үүсэх үр өгөөжийг эрх тэгш, шударга хуваарилах тухай Нагояагийн протоколыг соёрхон батлах, үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх

Стратегийн зорилго Д: Оролцогч талуудын хамтын төлөвлөлт, мэдлэгийг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлснээр замаар хэрэгжилтийг хангах;



2015 он гэхэд конвенцийн талууд Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болсон байх



2020 он гэхэд нутгийн уугуул иргэд, оршин суугчдын биологийн олон янз байдлыг хамгаалах, зүй зохистой ашиглах уламжлалт мэдлэг, хандлага, тэдгээрийн биологийн нөөц баялгийг ашиглаж ирсэн уламжлалт зан заншлыг хүлээн зөвшөөрч, үндэсний болон олон улсын хууль дүрэм, конвенцийн хэрэгжилтэнд бүрэн тусгасан байх



2020 он гэхэд Биологийн олон янз байдал, түүний үнэ цэнэ, төлөв байдал, хандлага, хомсдлоос учирч болзошгүй үр дагаврын талаарх шинжлэх ухааны үндэстэй мэдлэг, технологийг сайжруулах, өргөн хүрээгээр түгээн дэлгэрүүлэх, хэрэглэх



2020-он гэхэд "Биологийн олон янз байдлын стратегийн төвөвлөгөө 2010-2020"-г үр ашигтай хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг боломжит бүх эх үүсвэрээс бүрдүүлж одоогийн санхүүжилтийн түвшнээс эрс нэмэгдүүлэх. Конвенцийн талуудын хийсэн санхүүжилтийн хэрэгцээний үнэлгээнд үндэслэн энэхүү зорилтонд өөрчлөлт орох боломжтой.